



## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 4 сарын 21 өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

Дүрэм, заавар, маягт, гэрээний загвар батлах тухай 7

“Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Ашигт малтмал олборлох тухай гэрээ байгуулах өргөдөл”-ийн маягтыг 1 дүгээр хавсралтаар, “Ашигт малтмал олборлох гэрээ”-ний загварыг 2 дугаар хавсралтаар, “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гурвалсан гэрээ”-ний загварыг 3 дугаар хавсралтаар, “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн заавар”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг 5 дугаар хавсралтаар, “Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийн маягт”-ыг 6 дугаар хавсралтаар, “Бичил уурхайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хүрээнд авах арга хэмжээний төлөвлөгөө, тайлангийн маягт”-ыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын 2008 оны 149, 253 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

Гурав. Энэхүү тушаалаар батлагдсан гэрээ, дүрэм, заавар, маягтын загварыг бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хэрхэн ашиглах, дагаж мөрдөх талаар бичил уурхай эрхлэгчид болон аймаг, сум, дүүргийн Засаг дарга, Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллага, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс /Ц.Даваацэрэн/-т даалгасугай.

Дөрөв. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилт болон энэ тушаалаар батлагдсан дүрэм, заавар, маягт, гэрээний загварыг хэрэглэж байгаа практикийг судалж боловсронгуй болгох санал боловсруулж 2011 оны 12 дугаар сарын 1-ний дотор танилцуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс /Ц.Даваацэрэн/-т үүрэг болгосугай.

Тав. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийг Захиргаа, удирдлагын хэлтэс /Б.Түвшинжаргал/-т даалгасугай.



ДАРГА

Д.БАТХУЯГ